

**“Хай Би Ойл” ХК-ийн 2015 оны  
үйл ажиллагааны тайлан**

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот

Утас: 99098989, 99095728

Улсын бүртгэлийн мэдээлэл: № 9010001063,  
Регистрын дугаар № 2615134  
Үйл ажиллагааны чиглэл: Техникийн тосны үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа  
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 52,118,954

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд: Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

Тайлант хугацаанд үйлдвэрлэл болон боловсруулах тоног төхөөрөмжид ноцтой буюу гэнэтийн гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажилласан байна. 2015 он гарснаас хойш “Хай Би Ойл” ХК нь нийт 394’150 литр буюу 85’791’103 төгрөгийн түүхий эдийг гэрээтэй байгууллага болон хувь хүнээс хуримтлуулж, өмнөх оны 404’317 л бохир тосны үлдэгдлийн хамт нийтдээ 798’467 л түүхий эд цуглуулж авсан. Үүнээс тайлант хугацаанд 658’897 л хаягдал буюу бохир тосыг үйлдвэрлэлд оруулж, нийт 718’634 л мазутыг дараах байгууллагуудад 635’058’090 төгрөгөөр борлуулсан байна. Задаргааг харуулбал:

Үзүүлэлт	Нэгж	2014	2015
Татан төвлөрүүлсэн	тонн	687,4	798,5

Үзүүлэлт	Нэгж	2014	2015
Мазут	тонн	610,9	718,6

№	Худалдан авсан байгууллагын нэр	Хэмжээ /литр/	НӨАТ орсон үнэ /төгрөг/	
			Нэгж үнэ	Нийт үнэ
1	“Арж капитал” ХХК	6’066	891	5’405’400
2	“МБИндустрал” ХХК	65’000	900	58’500’000
3	“Монросцветмет” ХХК	109’400	990	108’306’000

4	“Монре транс трейд” ХХК	30’841	990	30’532’590
5	“Наранбулаг хан” ХХК	225’909	900	203’318’100
6	“Инфра инженеринг” ХХК	800	900	720’000
7	“УВТ инвест” ХХК	280’578	813	228’240’000
8	“Пено хийц” ХХК	40	900	36’000
<b>Бүгд дүн</b>		<b>718’634</b>		<b>635’058’090</b>

2015.12.31-ны өдрийн байдлаар түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний нөөц дараах байдалтай байна.

Түүхий эд буюу ажилласан маслын нөөц 41’851 литр

Боловсруулсан тос /Мазут/ 6’409 литр

2014 оноос хойш 8 байгууллагаас нийт 717,645,343 төгрөгийн авлагатай болоод байна.

Задаргааг дараах хүснэгтэд:

№	Авлагатай байгууллагын нэр	2014 он	2015 он
1	“Петроплас” ХХК	169’678’600	-
2	“Шарын гол” ХК	111’379’603	-
3	“Ялгуусан” ХХК	5’922’350	-
4	“Монросцветмет” ХХК	-	16’529’040
5	“Наранбулаг хан” ХХК	-	93’318’100
6	“МБИндустрал” ХХК	-	38’500’000
7	“УВТ инвест” ХХК	-	178’240’000
8	“Ашид мөнхийн зам” ХХК	-	104’077’650
<b>Бүгд дүн</b>		<b>286’980’553</b>	<b>447’324’520</b>
<b>2014-2015 нийлбэр дүн</b>		<b>717’645’343</b>	

Хөрөнгө оруулалт, засаж сайжруулсан зүйлс:

2015 оны эхний хагас жилд зарим түлхүүр багаж, худгийн насос, цахилгаан тоолуур, гүйдлийн трансформатор, ажилчдын хоолны хэрэглэлүүдийг шинэчилж, ажилчдын аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж дулааны улирлын нормын хувцас,

хамгаалалтын каск, савны цэвэрлэгээ үйлчилгээг хийх зориулалтын хамгаалах хувцас хэрэглэлүүдийг авсан. Үүнд нийт 2'478'300 төгрөгийг зарцуулсан байгаа.

Тайлант хугацаанд ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернд (Kia Rhino) ээлжит урсгал засвар, сэлбэг хэрэгсэл, улсын үзлэг, оношилгоо, даатгалд хамруулж 7'118'049 төгрөгийн зардал гарсан.

#### Хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж буй төсөл:

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015.07.02-ны өдрийн 302 тоот тогтоолын дагуу “Хай Би Ойл” ХК –ийн хаалттай хүрээнд нэмж гаргах нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 42,884,686 ширхэг энгийн хувьцааг бүртгэн тус тус компанийн нийт гаргасан хувьцааг 52,118,954 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан.

“Хай Би Ойл” ХК нь нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд 343 төгрөгөөс доошгүй үнээр тэргүүж ээлжинд худалдан авахыг хуульд заасан журмын дагуу санал болгон зохион байгуулж, гүйцэтгэлийг СЗХ-д тайлагнаж, компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэсэн.

“Хай Би Ойл” ХК нь нэмж хувьцаа гаргасантай холбоотойгоор компанийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхийг 343 төгрөгөөс доошгүй үнээр хэрэгжүүлэх арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан СЗХ-д тайлагнаж, олон нийтэд мэдээллийг хүргүүлсэн.

“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг нэр бүхий иргэд, хуулийн этгээдэд тэдгээрийн компанид олгосон зээлтэй хувь дүйцүүлэн эзэмшүүлж, өмчлөх эрхийг ҮЦТТТХТ баталгаажуулсан.

“Хай Би Ойл” ХК Малайз улсад бүртгэлтэй өөрийн охин компани болох HBOil (L) Berhad компанийг БНАСАУ-ын нийслэл Пхеньян хотод нээсэн. HBOil (L) Berhad компани нь БНАСАУ-ын үндэсний газрын тосны хайгуулын компани “Korea Oil Exploration Corp” компанитай хамтарсан төслийн нэг хэсэг болох БНАСАУ-ын эх газрын газрын тосны хайгуулын үйл ажиллагааг явуулах зорилготой юм.

2015 онд Хойд Солонгостой холбоотой үйл ажиллагааг харьцангуй бага зардалтайгаар явуулсан. Томилолтын тоо нэлээн цөөрсөн. Пхеньян хот дахь Янгадо зочид буудалд байрлах геологийн мэдээллийн төвийг байгуулсан ба шаардлагатай тоног техник хангамж болон программ хангамжийг суурилуулж улмаар БНАСАУ-д газрын тос байгалийн хийн чиглэлээр хийгдсэн бүх хайгуулын мэдээллүүд, геологи геофизикийн болон техникийн мэдээллүүдийг олж авч нэгтгэх, дахин боловсруулах, хөрвүүлэх ажлуудыг хийсэн. Гэрээний хугацаа дууссан, датарумыг Улаанбаатарт шилжүүлэн авчрахаар тохиролцож, 11 сараас зогсоож датарумыг буулгасан. Бүх хайгуулын ажлын тайлан, сайзмын мэдээлэл англи хэл дээр орчуулагдаад хадгалагдаж байна. Улаанбаатарт датарумыг шилжүүлж авчрах тал дээр Хойд Солонгосыхон хариугаа өгнө гэж ярьж байгаа.

**Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:**

Компанийн 2013, 2014, 2015 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	2013 он	2014 он	2015 он
Борлуулалт	115,5	722,7	614,0
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	115,5	722,7	614,0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	94,6	469,5	347,3
Нийт ашиг	20,9	253,2	266,7
Үйл ажиллагааны бусад орлого			
Үйл ажиллагааны зардалд	1017	404	441,3
Үйл ажиллагааны бус ашиг /алдагдал /	203,5	455,9	210,5
Үйл ажиллагааны бус зардал			
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал /	(792,6)	305,1	35,9
Орлогын татварын зардал	1,1	6,0	9,1
Цэвэр ашиг /алдагдал /	(793,7)	299,1	26,8

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, газрын төлбөр, авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь өгч, албан татварыг төлж байгаа.

2015 оны байдлаар 718,6 мянган литр мазут борлуулж 614,0 сая төгрөгийн орлого олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 347,3 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 441,3 сая төгрөг, хүүгийн орлого 91,4 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний ашиг 124,2 сая төгрөг, орлогын албан татвар 9,1 сая төгрөг зардалтай нийт 26,7 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

Компани нь 2015 онд НДШ -59,8 сая төгрөг, ААНОАТ-т 14,4 сая төгрөг, ХАОАТ-26,6 сая төгрөг, НӨАТ-т 33,1 сая төгрөг, газрын төлбөр 1,5 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татварт-4,7 сая төгрөг, Суутгагчийн хувь хүнд олгосон суутгасан албан татварт-4,8 сая төгрөг, АТӨЯХАТ-0,5 сая төгрөг нийт 145,4 сая төгрөг төлсөн.

Компанийн 2013 он, 2014 он, 2015 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	сая /төгрөгөөр /		
	2013 он	2014 он	2015 он
Эргэлтийн хөрөнгө	3097,8	3183,8	3261,7
Эргэлтийн бус хөрөнгө	6389,8	6498,4	6458,0
Нийт хөрөнгийн дүн	9487,6	9682,2	9719,7
Богино хугацаат өр төлбөр	9160,9	9056,4	704,7
Урт хугацаат өр төлбөр			
Эзэмшигчийн өмчийн дүн	326,7	625,8	9015
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	9487,6	9682,2	9719,7

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	Hermes Petroleum(L)Berhad	33.25%
2	Firebird Mongol Holdings A S.A.R.L	18.86%
3	Firebird Global Master Holdings-2 S.A.R.L	13.01%
4	Triton energy limtied	8%
5	“БиДиСЕК” ХК	6.98%

**Ногдол ашгийн талаархи мэдээлэл:**

Компани нь 2015 онд алдагдалтай ажилласан ба нэмж хувьцаа гаргасантай холбогдуулан 2015 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан.

**Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл**

Компани их хэмжээний хэлцэл хийгээгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэлийг Компанийн тухай хуулийн 89.1 дугаар зүйлийн дагуу хийсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Пүрэвбаатар, Кэйт Беннетт, Ж.Эрдэмбилэг, хараат бус гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн, түр гишүүнээр Д.Даянбилгүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Лхагвадорж, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргачийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	дээд
2	Өлзийсайхан овогтой Хүдрээ	Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн ердийн гишүүн,	дээд
3	Баярсайхан овогтой Пүрэвбатаар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү эрхэлсэн захирал	дээд
4	Кэйт Беннетт	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
5	Жүгдэрнамжил овогтой Эрдэмбилэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
7	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Мажигсүрэн овогтой Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Сий Кок Хенг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

“Хай Би Ойл” ХК 2015 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2015 оны 05 сарын 13-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг, Б.Пүрэвбаатар, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Батхишигийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Ж.Эрдэмбилэг, Х.Батхишиг, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Х.Батхишиг, М.Батсүрэн, Кэйт Беннетт гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Кэйт Беннетт-г томилсон.

“Хай Би Ойл” ХК 2014 оны 04 сарын 22-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

“Хай Би Ойл” ХК 2013 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2012 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн санхүүгийн талаарх ТУЗ-ын дүгнэлт
3. Компанийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
4. Компанийн 2013 оны ажлын төлөвлөгөө
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох
6. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2013 оны зардлын төсөв батлах
7. Ноогдол ашгийн талаар